

ГЕРМАНЫ ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ
БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ОРХОН АЙМГИЙН НЭГ ЦОНХНЫ ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ БИЗНЕС ШИРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн
Монгол дахь Бүс Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөрийн
Бүс Нутгийн Эдийн Засгийн бодлого боловсруулахад
дэмжлэг үзүүлэх хэсгээс бэлтгэн гаргав.

2009 оны 4 сар

Бүс Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилтот бүс нутаг болох Дархан, Эрдэнэт, Улиастайн эдийн засгийн бүсүүдэд орон нутгийн нөөц бололцоог бүрэн ашиглах замаар бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, хөгжих нөхцөл бололцоог сайжруулахад Бүс Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөрийн зорилго оршино. Хөтөлбөр нь дор дурьдсан 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

- Орон нутаг дахь бизнес үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх замаар ЖДҮ эрхлэгчид болон хоршоодын үйл ажиллагааг дэмжих
- ЖДҮ эрхлэгчид болон хоршоодод үзүүлдэг санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх
- Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх гэсэн үндсэн 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Хөдөө орон нутагт чиглэсэн хөтөлбөрийн үйл ажиллагаа нь бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, БЖДҮ эрхлэгчдийг санхүүгийн үйлчилгээнд илүү ойртуулж эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх замаар орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Бүрэлдэхүүн хэсэг 3. Бүс нутгийн эдийн засгийн бодлого ба бизнесийн орчин

Бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай зохицуулалт, удирдлага зохион байгуулалтын бүтцийг сайжруулах, бодлогын бичиг баримтыг оролцооны аргад тулгуурлан боловсруулахад бүс нутгийн захиргааны байгууллагуудад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой.

Үйл ажиллагаа

Аймгийн хөгжлийн хөтөлбөр: Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлого, бүсийн хөгжлийн хөтөлбөрийг аймаг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжих **аймгийн хөгжлийн стратеги** боловсруулах үйл ажиллагаанд арга зүйн зөвлөмж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Боловсон хүчнийг чадавхжуулах: Бүс нутагт ажиллаж буй захиргааны ажилтнуудыг Бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалт, семинар, туршлага судлах аян зэргийг зохион байгуулж байна.

Уулзалт хэлэлцүүлэг ба ажлын хэсэг: Хөтөлбөрийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх үүднээс орон нутгийн түвшинд төрийн болон төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын төлөөллийг багтаасан ажлын хэсгүүдийг байгуулан

хөтөлбөрийн зорилтот бүс нутгуудад ажиллуулж байна. Эдгээр ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь бизнесийн хэвийн таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн хөгжлийг хангахад саад болж буй асуудлуудыг илрүүлэн түүнийг шийдвэрлэх санал боловсруулж орон нутгийн болон үндэсний хэмжээний шийдвэр гаргагч, хууль тогтоогчидод хүргэхэд оршино.

Нэг цонхны үйлчилгээ: Төрийн байгууллага дахь хүнд суртлыг багасгаж бизнес эрхлэгчдэд үзүүлж буй үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй болгох **Нэг цонхны үйлчилгээ** бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран техникийн туслалцаа үзүүлж байна.

Бизнес эрхлэгчдэд нэн хэрэгцээтэй төрийн үйлчилгээний төрлийг тодорхойлж **нэг цонхны үйлчилгээнд** хамруулснаар бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд дөхөм болох юм. Үүний тулд төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний талаар хэрэглэгчдийн дунд суурь судалгааг шат дараатайгаар зохион байгуулж, бизнес эрхлэгчдэд төрөөс үзүүлж буй үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломжийг олгох зорилгоор нэг цонхны үйлчилгээнд «Бизнес ширээ»-г хөтөлбөр хэрэгжиж буй бүс нутгуудад нээн ажиллуулахаар ажиллаж байна.

Оршил

Бүс нутагт бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэхэд төрөөс БЖДҮ, бизнес эрхлэгчдэд чиглэсэн үйлчилгээг хурдан шуурхай, хүнд сурталгүй хүргэх зорилгоор төрийн үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэн хүргэх бодлогыг Монгол Улсын Засгийн газраас баримталж байгаа билээ.

Аймгийн түвшин дэх нэг цонхны үйлчилгээний үзэл санаа концепцыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг Швейцарын Хөгжлийн Агентлаг дэмжин ажиллаж байгаа бөгөөд ГТХАН нь ЦХА-тай НЦҮ-ний концепцыг боловсруулах хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Уг гэрээний хүрээнд ГТХАН-ийн зүгээс Бүс Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөр хэрэгжиж буй бүс нутаг болох Дархан-Уул, Орхон, Завхан аймгуудад Нэг цонхны үйлчилгээнд, бизнес эрхлэхтэй холбогдсон үйлчилгээнүүдийг нэгтгэн үзүүлэх «Бизнес ширээ» –г бий болгохыг дэмжин ажиллаж байгаа юм.

«Бизнес ширээ»-ий концепцыг боловсруулахад БНЭЗДХ-өөс богино хугацааны мэргэжилтэн доктор Александр Вегенерийг урьж ажиллуулсан бөгөөд төрийн үйлчилгээний хэрэглэгчийн судалгаа, бизнесийхэнд хамгийн их эрэлт хэрэгцээтэй байдаг төрийн үйлчилгээг тодруулах асуулга, төрийн үйлчилгээний давтамж, үргэлжлэх хугацааг нягтлах асуулгыг үе шаттайгаар зохион байгуулж «Бизнес ширээ» -нээс үзүүлэх үйлчилгээний жагсаалт болон бусад мэдээллийг агуулсан «Нэг цонхны үйлчилгээн дэх Бизнес Ширээний танилцуулга»-ыг орон нутаг дахь төрийн захиргааны болон ТББ-тай хамтран боловсрууллаа. Уг танилцуулгатай холбоотой санал шүүмжийг манай хөтөлбөрийн хаягаар хүргүүлнэ үү.

Хөтөлбөрийн зүгээс үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад Бизнес ширээний үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох, БЖДҮ, бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэн сайжруулахад үйл ажиллагаагаа чиглэн ажиллах болно.

Нэг цонхны үйлчилгээн дэх Бизнес ширээний танилцуулга нь БЖДҮ, бизнес эрхлэгчид, шинээр бизнес эрхлэхийг зорьж буй иргэд болон ажилтануудад тус ширээнээс үзүүлэх үйлчилгээний талаар холбогдох мэдээллийг өгч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

БНЭЗДХ-ийн Ерөнхий Зохицуулагч
Ахлах мэргэжилтэн

Йоханнес Фон Франц
Д.Ерөө

Нэгдсэн үндэстний гудамж 8/2
Чингэлтэй дүүрэг, 4-р Хороо
Улаанбаатар 210646, Монгол улс
Вэб хаяг: www.red-mongolia.mn

Утас: +976 11 70112838
+976 11 329075
Факс: +976 11 70111828

Агуулга

1. Оршил	4
2. Нэг цонхны үйлчилгээн дэх Бизнес ширээ	7
3. Бизнес үйлчилгээний лавлах	8
4. Бизнес ширээнээс үзүүлэх үйлчилгээний жагсаалт	9
5. Төрийн болон Бизнес Хөгжлийн Үйлчилгээ Үзүүлэгч Байгууллагуудаас үзүүлэх үйлчилгээний мэдээллийн хуудас	15
6. Бизнес ширээнээс үзүүлэх үйлчилгээний шат дамжлагын зураглал	39

Товчилсон үгийн тайлбар

НЦҮ	-	Нэг Цонхны Үйлчилгээ
ГТХАН	-	Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ЩХА	-	Щвецарын Хөгжлийн Агентлаг
БНЭЗДХ-		Бүс Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөр
БҮЛ	-	Бизнес Үйлчилгээний Лавлах
БХҮҮБ	-	Бизнес Хөгжлийн Үйлчилгээ Үзүүлэгч Байгууллага
ХАҮТ	-	Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
АОЭХ	-	Ажил Олгогч Эздийн Холбоо
ХСТ	-	Хоршоодын Сургалтын Төв
ЖДҮДТ-		Жижиг Дунд Үйлдвэрийг Дэмжих Төв
ЗДТГ	-	Засаг Даргын Тамгын Газар
ААН	-	Аж Ахуйн Нэгж
ХХК	-	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ГХО	-	Гадаадын Хөрөнгө Оруулалт
ИТХ	-	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХГ	-	Мэргэжлийн Хяналтын Газар
СХЗТ	-	Стандарт Хэмжил Зүйн Төв
ОБГ	-	Онцгой Байдлын Газар
БОА	-	Байгаль Орчны Алба
БСГ	-	Боловсрол Соёлын Газар
ЭМГ	-	Эрүүл Мэндийн Газар
ХЗА	-	Хотын Захирагчын Алба
БЖДҮ	-	Бичил Жижиг Дунд Үйлдвэр

Нэг цонхны үйлчилгээ- Бизнес ширээ

НЦҮ нь төрийн байгууллагуудаас иргэд, ААН байгууллагад үзүүлж буй олон төрлийн үйлчилгээг, ялангуяа хамгийн их эрэлттэй үйлчилгээнүүдийг нэг цэгээс үзүүлэх орон нутгийн засаг захиргааны нэгж юм.

НЦҮ дэх Бизнес ширээний үзэл санаа нь БЖДҮ, бизнес эрхлэгчдэд төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээнүүдийг нэг дороос үзүүлэхэд оршино.

Бизнес үйлчилгээний зорилго:

Төрийн бүх төрлийн бүртгэл, лизенц, зөвшөөрөл, хяналт, ТББ-аас үзүүлж буй бизнесийг хөгжүүлэх дэмжлэг, санхүү болон хуулийн мэргэжлийн зөвлөгөө, орон нутгийн мэргэжлийн холбоодын үйлчилгээг төвлөрүүлэн хүртээмжтэй болгох.

Бизнес ширээнээс үзүүлэх үйлчилгээ:

- Шинээр бизнес эрхэлж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд үзүүлэх үйлчилгээ
- Бизнесээ өргөжүүлэх хүсэлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээ
- Бизнес эрхлэгчдэд зориулсан зуучлалын мэдээлэл



Бизнес үйлчилгээний лавлах

Бизнес Үйлчилгээний Лавлах нь БЖДҮ, бизнес эрхлэгчдэд үзүүлж буй төрийн бүх төрлийн үйлчилгээ, бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд (Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо, Хоршоодын сургалтын төв гэх мэт), банк санхүүгийн байгууллагууд болон мэргэжлийн холбоодын үзүүлэх үйлчилгээний мэдээллийн жагсаалтыг агуулна.

Лавлах нь: Нэг цонхны үйлчилгээн дэх Бизнес ширээгээр үйлчлүүлэгчид болон Бизнес ширээний ажилтанд мэдээлэл зөвлөгөөний хэрэгсэл болно.



Бизнес ширээнээс үзүүлэх үйлчилгээний жагсаалт

Бизнес ширээнээс үзүүлэх үйлчилгээний жагсаалт

1. ААН БАЙГУУЛАХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ- ТАТВАРЫН ХЭЛТЭС /БҮРТГЭЛИЙН АЛБА/

№	Үйлчилгээний нэр
1	Бүртгэл: Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг бүртгэх
2	Бүртгэл: Нөхөрлөлийг бүртгэх
3	Бүртгэл: Үйлдвэрийн газрыг бүртгэх
4	Бүртгэл: Хоршоог бүртгэх
5	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл: Дансны өөрчлөлтийг бүртгэх
6	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл: Хаягийн өөрчлөлтийг бүртгэх
7	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл: Удирдлагын өөрчлөлтийг бүртгэх
8	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл: Үүсгэн байгуулагчийн өөрчлөлтийг бүртгэх
9	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл: Дүрмийн сангийн өөрчлөлтийг бүртгэх
10	Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл: Эрхлэх үйл ажиллагааны өөрчлөлтийг бүртгэх
11	Хуулийн этгээдийг татан буулгах

2. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ

№	Үйлчилгээний нэр	Мэргэжлийн байгууллагын нэр
1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийх	Байгаль орчны алба
2	Галын аюулгүйн байдлын дүгнэлт гаргах, сунгах	Онцгой байдлын хэлтэс
3	Стандарт олгох	Стандарт Хэмжил Зүйн Төв
4	Улсын байцаагчийн дүгнэлт гаргах, сунгах	Мэргэжлийн хяналтын газар
5	Гарал үүслийн гэрчилгээ олгох	ХАҮТ
6	Бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох	ХАҮТ
7	Патент барааны тэмдгийг бүртгүүлэхэд зуучлах	ХАҮТ

3. ЗӨВШӨӨРӨЛ, ЛИЦЕНЗ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭ

№	Үйлчилгээний нэр	Мэргэжлийн байгууллагын нэр
1	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгох	БСГ-АЗДТГ
2	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох	АЗДТГ
3	Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох	Сумын ЗДТГ
4	Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа явуулах лиценз олгох	ЭМГ-АЗДТГ

4. БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Үйлчилгээний нэр	Байгууллагын нэр
1.	Бизнесийг хөхүүлэн дэмжих, урамшуулах	ХАҮТ
2.	Гадаад, дотоод худалдааны маргаан шийдвэрлэх Арбитрын шүүх Бизнесийн өмгөөлөл	ХАҮТ
3.	Экспорт, импортын барааг магадлан шалгах	ХАҮТ
4.	Патент барааны тэмдгийг бүртгүүлэхээр зуулчлах	ХАҮТ
5.	Монгол улсад үйлдвэрлэснийг гэрчлэх, гарал үүслийн гэрчилгээ олгох	ХАҮТ
6.	Бараа, бүтээгдэхүүнд зураасан код олгох	ХАҮТ
7.	Давагдашгүй хүчин зүйлийн баталгаа гаргах	ХАҮТ
8.	Бие даан болон хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	ХАҮТ
9.	Хөрөнгө оруулалт, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээр зээл, төсөл, хөтөлбөрт зуучлах	ХАҮТ
10.	Зах зээлийн мэдээлэл солилцох, үйлдвэр худалдааны түнш эрж олохтой холбогдсон мэдээллээр хангах	ХАҮТ
11.	Дотоод гадаадын, Олон улсын болон төрөлжсөн үзэсгэлэн яармаг зохион байгуулах, оролцох	ХАҮТ
12.	Гадаадын үзэсгэлэн худалдаанд оролцуулах бизнес группын айлчлал, аялалуудыг зохион байгуулах	ХАҮТ
13.	Компаниудад гадны зөвлөх мэргэжилтэн урьж ажиллуулах	ХАҮТ
14.	Хувийн хэвшлийн аж ахуй нэгж /ХХААН/ шинээр байгуулахад нь компани нөхөрлөл, хоршооллын тухай хууль дүрмийг танилцуулж, ААН-ийн хэлбэрийг сонгоход нь заавар зөвлөлгөө өгөх	АОЭХ
15.	Шинэ байгууллагынхаа дүрмийг боловсруулахад зөвлөж туслах	АОЭХ
16.	Эдийн засаг санхүүгийн судалгаа тооцоо хийхэд нь зөвлөх	АОЭХ
17.	Цаашид эрхлэх бизнесийнх нь талаар зах зээлтэй уялдуулан зарим талаар зөвлөгөө өгөх	АОЭХ

18.	Орон нутгийн төр, захиргааны байгууллагад түүнтэй гурван талт хэлэлцээр хийдэг эрх үүргийнхээ дагуу ХХААН-ийг дэмжиж туслах талаар дараах чиглэлээр асуудал тавьж, ярьж, шаардаж шийдвэрлүүлдэг. а/ Газар эзэмших асуудал б/ Байр түрээслэх зэрэг асуудал в/ Ажлын байртай болгох г/ Мэргэжлийн ажилчдаар хангахад дэмжлэг авах д/ Шинээр байгуулагдсан ААН-д татварын хөнгөлөлт үзүүлэх е/ Аж ахуй, үйл ажиллагааны маргаан гарвал хувийн хэвшлийн дээд байгууллагын хувьд хууль хяналтын байгууллагууд асуудал тавьж шийдвэрлүүлэх ё/ Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг нь борлуулах зах зээлийн асуудал ж/ Татвар, мэргэжлийн хяналт шалгалт зэрэг байгууллагуудтай харьцахад хүндрэл гарвал дэмжиж туслах зэрэг болно.	АОЭХ
19.	МАОЭНХ-оос 21 аймаг хотуудад ээлжлэн зохион байгуулдаг зах зээл, бизнесийн хурал, семинар сургалтад ажил олгогчдыг өргөн оролцуулж туршлага судлуулж, мэдлэгийг нь дээшлүүлэхэд байнга анхаардаг.	АОЭХ
20.	Дээрх чиглэлийн хурал, семинар сургалтыг Эрдэнэт хотод зохион байгуулж байдаг	АОЭХ
21.	ХХААН-ийг хөгжүүлж бэхжүүлэхэд онолын болон практик үйл ажиллагааны чиглэлээр гадаад орнууд тухайлбал АНУ, Хятад, Орос, Япон, Герман, Солонгос, Сингапур, Тайван зэрэг орнуудад Ажил олгогчдын төлөөллийг явуулж, хурал зөвлөгөөн, семинар, сургалтад байнга оролцуулж байдаг болно.	АОЭХ
22.	Орон нутагт эрхлэх боломжтой жижиг бизнесийн талаар ерөнхий мэдээлэл өгөх	Хоршоодын сургалт мэдээллийн төв
23.	ЖДҮ, хоршоодод санхүүгийн дэмжлэг авах боломжийн талаарх мэдээлэл	Хоршоодын сургалт мэдээллийн төв
24.	Бизнес эрхлэгчдэд хэрэгцээт сургалт хийх	Хоршоодын сургалт мэдээллийн төв
25.	Бизнес эрхлэгчдэд хэрэгцээт зөвлөгөө өгөх	Хоршоодын сургалт мэдээллийн төв
26.	Бизнес эрхлэгчдэд хэрэгцээт мэдээлэл хүргэх	Хоршоодын сургалт мэдээллийн төв
27.	Бизнес эрхлэгчдийг хэрэгцээт гарын авлага материалаар хангах	Хоршоодын сургалт мэдээллийн төв
28.	Бизнес эрхлэгчдийг төсөл, хөтөлбөрт зуучлах	Хоршоодын сургалт мэдээллийн төв

**Төрийн болон Бизнес Хөгжлийн
Үйлчилгээ Үзүүлэгч Байгууллагуудаас
үзүүлэх үйлчилгээний Мэдээллийн
хуудас**

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙГ БҮРТГЭХ

Үйлчилгээний тодорхойлолт, үндэслэл: Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно. Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

Эрх зүйн орчин: Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхдээ «Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай» «Тэмдэгтийн хураамжийн» «Компанийн тухай» «Нөхөрлөлийн тухай» «Хоршооны тухай» «Төрийн болон орон нутгийн өмчийн тухай» «Гадаадын хөрөнгө оруулалтын тухай» хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, албаны дүрэм, ажлын байрны тодорхойлолт

Бүрдүүлэх материал:

1. Батлагдсан маягтын дагуу өргөдөл бөглөх 2% /гарын үсгийг нотариатаар батлуулах/
2. Үүсгэн байгуулах шийдвэр 2%
3. Компанийн дүрэм 2%
4. Анкет 2% /зурагтай/
5. Иргэний үнэмлэхний хуулбар 2%
6. Баланс 2%
7. Данс нээлгэх /татварын албанаас шар хуудас авах/
8. Дүрмийн сан хөрөнгөөр бүрдүүлэх бол хөрөнгийн жагсаалт 2% /тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийг компанийн нэр дээр бүртгүүлсний дараа нэмэлт өөрчлөлтөөр гэрчилгээнд бүртгүүлэх/
9. Дүрмийн сан мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бол нээлгэсэн дансандаа мөнгөн хөрөнгөө байршуулсан баримт
10. Тэмдэгтийн хураамж 10000 төгрөгийг Төрийн сан банк 210000941 тоот дансанд тушаасан баримт
11. Нэрийн лавлагааны баримт
12. Хувийн хэргийн хавтасны үнэ бэлнээр төлөх

Үйлчилгээний үнэ өртөг: Тэмдэгтийн хураамж 10000 төгрөг

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: Ажлын 5 хоног

Хэн хариуцах: Орхон аймгийн татварын хэлтэс, Улсын бүртгэл хариуцсан байцаагч.

Утас: 01352-22590

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдол хаана гаргах: Орхон аймгийн татварын хэлтсийн дарга

Утас: 01352-21803

НӨХӨРЛӨЛИЙГ БҮРТГЭХ

Үйлчилгээний тодорхойлолт, үндэслэл: Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

Эрх зүйн орчин: Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхдээ «Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай» «Тэмдэгтийн хураамжийн» «Компанийн тухай» «Нөхөрлөлийн тухай» «Хоршооны тухай» «Төрийн болон орон нутгийн өмчийн тухай» «Гадаадын хөрөнгө оруулалтын тухай» хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, албаны дүрэм, ажлын байрны тодорхойлолт

Бүрдүүлэх материал:

1. Батлагдсан маягтын дагуу өргөдөл бөглөх 2% /гарын үсгийг нотариатаар батлуулах
2. Нөхөрлөл байгуулах тухай үсгэн байгуулагч гишүүдийн хурлын протокол, тогтоол 2%
3. Үүсгэн байгуулах гэрээ 2% /Нотариатаар батлуулсан байх/
4. Гишүүн бүрийн анкет 2% /зурагтай/
5. Иргэний үнэмлэхний хуулбар 2%
6. Эхлэлтийн баланс 2%
7. Данс нээлгэх /татварын албанаас шар хуудас авах/
8. Дүрмийн сан хөрөнгөөр бүрдүүлэх бол хөрөнгийн жагсаалт 2% /тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийг компанийн нэр дээр бүртгүүлсний дараа нэмэлт өөрчлөлтөөр гэрчилгээнд бүртгүүлэх/
9. Дүрмийн сан мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бол нээлгэсэн дансандаа мөнгөн хөрөнгөө байршуулсан баримт
10. Тэмдэгтийн хураамж 10000 төгрөгийг Төрийн сан банк 210000941 тоот дансанд тушаасан баримт
11. Нэрийн лавлагааны баримт
12. Хувийн хэргийн хавтасны үнэ бэлнээр төлөх

Үйлчилгээний үнэ өртөг: Тэмдэгтийн хураамж 10000 төгрөг

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: Ажлын 5 хоног

Хэн хариуцах: Орхон аймгийн татварын хэлтэс, Улсын бүртгэл хариуцсан байцаагч

Утас: 01352-22590

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдол хаана гаргах: Орхон аймгийн татварын хэлтсийн дарга
утас: 01352-21803

ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ БҮРТГЭХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэх

Эрх зүйн орчин: Монгол улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

Шаардагдах бичиг баримт, бүртгүүлэх материал:

1. Гүйцэтгэх удирдлагын иргэний үнэмлэх
2. Үйлдвэрийн газрын оноосон нэрийн санал/ 5-аас доошгүй/
3. Үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулах шийдвэр
4. Гүйцэтгэх удирдлагын цээж зураг/2 хувь/
5. Холбогдох газартай гүйцэтгэх удирдлагын байгуулсан гэрээ
6. Байрны түрээсийн гэрээ буюу өөрийн байрыг гэрчилсэн баримт
7. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх бол эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл

Үйлчилгээний үнэ өртөг:

1. Үйлдвэрийн газрын нэрийг баталгаажуулах хуудасны үнэ 1200 төгрөг
2. Улсын бүртгэлд бүртгэсний хураамж 10000 төгрөг
3. Бүрдүүлсэн бичиг баримтыг хадгалах хавтасны үнэ 3000 төгрөг

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа:

Бүртгэлийг ажлын 5 хоногт багтаан бүртгэнэ.

Хариуцсан эзэн, нэгж:

Бүртгэл хийх байгууллага нь: Аймгийн Татварын хэлтэс, бүртгэлийн мэргэжилтэн

Утас: 01352-22590

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдол хаана гаргах: Орхон аймгийн татварын хэлтсийн дарга
утас: 01352-21803

ХОРШООГ БҮРТГЭХ

Үйлчилгээний тодорхойлолт, үндэслэл: Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно. Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

Эрх зүйн орчин: Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхдээ «Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай» «Тэмдэгтийн хураамжийн» «Компанийн тухай» «Нөхөрлөлийн тухай» «Хоршооны тухай» «Төрийн болон орон нутгийн өмчийн тухай» «Гадаадын хөрөнгө оруулалтын тухай» хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, албаны дүрэм, ажлын байрны тодорхойлолт

Бүрдүүлэх материал :

1. Батлагдсан маягтын дагуу өргөдөл бөглөх 2% /гарын үсгийг нотариатаар батлуулах/ маягтыг татварын хэлтсээс авах
2. Хоршоо байгуулах тухай үүсгэн байгуулагч гишүүдийн хурлын протокол, тогтоол 2%
3. Хоршооны дүрэм 2% /Хадгаламж зээлийн хоршооны хувьд хоршооны дүрмэнд дараах журмуудыг хавсаргана.
 - Зээл олгох
 - Хадгаламж авах
 - Хоршооны зээлийн сан
 - Зээлийн эрсдэлийн сан
 - Бусад сан байгуулах , зарцуулах журам
 - Хадгаламж зээлийн үйл ажиллагаанд оролцох журам
4. Гишүүн бүрийн анкет 2% /зурагтай/
5. Иргэний үнэмлэхний хуулбар 2%
6. Гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл /өргөдлийн маягтын хүснэгтээр/
7. Гишүүдээс хөрөнгө хүлээн авсан жагсаалт /гарын үсэгтэй/
8. Эхлэлтийн баланс 2%
9. Данс нээлгэх /татварын албанаас шар хуудас авах/
10. Дүрмийн сан хөрөнгөөр бүрдүүлэх бол хөрөнгийн жагсаалт 2% /тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийг компанийн нэр дээр бүртгүүлсний дараа нэмэлт өөрчлөлтөөр гэрчилгээнд бүртгүүлэх/
11. Дүрмийн сан мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бол нээлгэсэн дансандаа мөнгөн хөрөнгөө байршуулсан баримт
12. Тэмдэгтийн хураамж 6000 төгрөгийг Төрийн сан банк 210000941 тоот дансанд тушаасан баримт
13. Нэрийн лавлагааны баримт
14. Хувийн хэргийн хавтасны үнэ бэлнээр төлөх
15. Татвар төлөгчийн маягт бөглөж хариуцсан байцаагчид бүртгүүлэх

Үйлчилгээний үнэ өртөг: Тэмдэгтийн хураамж 6000 төгрөг

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: Ажлын 5 хоног

Хэн хариуцах: Орхон аймгийн татварын хэлтэс, Улсын бүртгэл хариуцсан байцаагч.

Утас: 01352-22590

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдол хаана гаргах: Орхон аймгийн татварын хэлтсийн дарга, утас: 01352-21803

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ

Үйлчилгээний тодорхойлолт, үндэслэл: Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно.Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

Эрх зүйн орчин: Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхдээ «Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай» «Тэмдэгтийн хураамжийн» «Компанийн тухай» «Нөхөрлөлийн тухай» «Хоршооны тухай» «Төрийн болон орон нутгийн өмчийн тухай» «Гадаадын хөрөнгө оруулалтын тухай» хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, албаны дүрэм,ажлын байрны тодорхойлолт

Бүрдүүлэх материал:

- Нэмэлт өөрчлөлтийн өргөдлийн маягт УБ-05-ыг бөглөх
- Үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр
- Шинэчлэн найруулсан гэрээ дүрэм 2%, буюу гэрээ, дүрэмд хийсэн өөрчлөлтийн баримт 2%
- Гишүүнээр орох, гарах хүний өргөдөл
- Өөрчлөгдсөн удирдлага болон үүсгэн байгуулагчийн анкет иргэний үнэмлэхийн хуулбар 2%
- Тэмдэгтийн хураамж төлсөн баримт/ өөрчлөлт бүрд 1000 төгрөг/ төрийн сан банк 210000941 тоот дансанд/
- Дүрмийн санг нэмсэн бол нотлох хөрөнгийн жагсаалт буюу, банкинд төвлөрүүлсэн мөнгөний баримтын хуулбар
- Данс нээсэн буюу хаасан бол мэдэгдэл бөглөнө.
- Тусгай зөвшөөрөлийн хуулбар
- Салбар байгуулах бол гэрчилгээний үнэ 5000 төгрөг төлсөн баримт, удирдлагын анкет, үнэмлэхний хуулбар
- Нэр солих бол нэр шүүлгэх 1500 төгрөг тушаасан баримт
- Гэрчилгээ дахин авах бол гэрчилгээний үнэ- 15000төгрөг, тэмдэгтийн хураамж 1000 төгрөг тушаах

Үйлчилгээний үнэ өртөг: Тэмдэгтийн хураамж 1000 төгрөг

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: Ажлын 5 хоног

Хэн хариуцах: Орхон аймгийн татварын хэлтэс, Улсын бүртгэл хариуцсан байцаагч.

Утас: 01352-22590

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдол хаана гаргах: Орхон аймгийн татварын хэлтсийн дарга утас:01352-21803

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, алдагдахаас урьдчилан сэргийлэх, байгалийн нөөц баялгийн ашиглалтыг зохицуулах, орчны бохирдолтыг бууруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлж, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна.

«Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ» гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж түүнийг багасгах, арилгах арга хэмжээ тогтооход оршино.

Эрх зүйн орчин:

- Байгаль орчинг хамгаалах тухай хууль /7,9-р зүйл/
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Газрын тухай хууль /34.2, 34...3, 34.4 дэх заалтууд

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийхэд бүрдүүлэх материал:

1. БОНБ-ын үнэлгээ хийлгүүлэх тухай албан хүсэлт
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ
3. Төслийн байршил хэрэгжих орчны тойм зураг
4. Төслийн техник эдийн засгийн үндэслэл
5. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан эсэх баримт
6. Төслийн товч тодорхойлолтууд
7. Технологийн шийдэл
8. Холбогдох гэрээнүүд

Үйлчилгээний үргэжлэх хугацаа: Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг шинжээс ажлын 12 хоногт багтааж хийж дүгнэлт гаргана. /БОНБ Үнэлгээний тухай хуулийн 4.6 дахь заалт/ БОНБЕрөнхий үнэлгээг БОАЖГазрын мэргэжилтэн шинжээч хийж газрын дарга хянаж баталгаажуулна.

Хэн хариуцах: Орхон аймгийн БОАЖГазрын БО, Үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Утас: 01352-27892, 99950013

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00, 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдлыг хаана гаргах: Орхон аймгийн БОАЖГазрын дарга Утас: 01352-20872

АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ

Үйлчилгээний тодорхойлолт, үндэслэл: Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ажлын байрны галын аюулгүй байдлыг хангуулах, энэ тухай мэргэжлийн байгууллагын нотлох баримтыг олгоход оршино.

Эрх зүйн орчин:

1. Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлэгийн 16 дугаар зүйл, 4 дүгээр бүлэгийн 18, 20, 21-р зүйл
2. Гал түймэртэй тэмцэх газрын даргын 2001 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн °198 тоот тушаал « Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт » олгох журам батлах тухай.

Шаардагдах бичиг баримт, бүрдүүлэх материал:

Дүгнэлт гаргуулах байгууллага ажлын байрны галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийсэн байна.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, ажлын байрны байршлын схем зураг, газар олголтын захирамжийг хавсаргана.
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь объектын ажлын байрны галын аюулгүй байдлыг дараах стандартын дагуу хангана. Үүнд:
 - 100 м² тутамд гал унтраагуулыг төлөвлөн байршуулах
 - Объектын өрөө тасалгааны зам гарцын схем зургыг блок, блокоор секцлэн давхар тус бүрт байрлуулах
 - Гал эсэргүүцэх анхан шатны багаж хэрэгслийн MNS-5566 стандартыг баримтлах
3. Гал унтраах дотуур, гадуур усан хангамж, галын дохиоллын мэдрэгч системээр тоноглох
4. Аймгийн Онцгой байдлын газрын www.erdenet.mn хаягаар орж, галын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн эрхзүй, стандарт нормтой танилцах
5. Ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлтээ ОБГ-ын 301 тоот өрөөнд ирүүлэх

Үйлчилгээний үнэ өртөг: ХЗДХэргийн сайдын 2001 оны 226, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 127 дугаар тушаалаар тогтоосон үнэ тарифийг мөрдлөгө болгоно.

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: Иргэдээс ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн материалтай танилцаж ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Хариуцах эзэн, нэгж: Орхон аймгийн Онцгой байдлын газрын орлогч, ажлын албаны дарга

Утас: 01352-20394

Ажиллах цаг:

Ажиллах өдөр	Ажиллах цаг
Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан	0800 -1200 , 1400-1800

СТАНДАРТ ОЛГОХ

Хуулийн нөхцөл: «Стандартчилал хэмжилзүйн тухай хууль»

Стандарт олгох үйл ажиллагааны дараалал

1. Монгол улсын стандартын жагсаалт www.gov.mn хаягаар орж стандартын жагсаалтаас харах
2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд буюу хэрэглэгчийн стандартын захиалгын хуудас бөглөнө. /Төрийн сан банкинд захиалсан стандартын үнийг тарифын дагуу төлнө/
3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд захиалах стандартын үнийг /тарифт үнээр/ банкинд тушааж баримт авна.
4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд буюу хэрэглэгчийн стандартын захиалга өгнө

Үйлчилгээний үргэлжлэх хугацаа:

- СХЗТ нь материалыг хүлээн авснаас хойш 15 хүртлэх стандартыг ажлын 3 хоногт, 15-30 хүртэлх стандартыг ажлын 5 хоногт багтаан олгоно.
- Орон нутагт байхгүй стандартын захиалгыг СХЗҮТ-д хүргэж захиалгыг авч өгөх ба энэ тохиолдолд ажлын 14 хоногт багтаан стандартыг олгоно.

Хэн хариуцах: Орхон аймгийн Стандартчилал хэмжилзүйн төвийн мэргэжилтэн

Утас: 01352-26919

Ажиллах цаг:

Ажиллах өдөр	Ажиллах цаг
Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан	0800 -1200 , 1400-1800

Стандарт олгохтой холбоотой иргэн ААН-н санал, хүсэлт, гомдлыг: Орхон аймгийн Стандартчилал хэмжил зүйн төвийн даргад гаргана.

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Үйлдвэрлэл үйлчилгээ явуулах барилга байгууламжийг хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал холбогдох стандарт шаардлагад нийцүүлэн арга хэмжээг зохицуулахад оршино.

Эрх зүйн орчин:

- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Хөдөлмөрийн хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал
- Эрүүл ахуйн тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль

Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх материал:

1. Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах тухай өргөдөл
- ААН- бол албан тоот
2. Иргэний үнэмлэхний хуулбар
- ААН-н гэрчилгээний хуулбар
3. Ажлын байр нь өөрийн өмчлөлийн байр бол түүнийг нотлох баримт, гэрчилгээ
4. Ажлын байр нь түрээсийн байр бол түрээсийн гэрээ
5. Газрын харилцааны эрх үүссэн зөвшөөрөл
6. Тухайн объектын байршлын схем

Үйлчилгээний үргэжлэх хугацаа: Улсын байцаагчийн дүгнэлт гаргахад ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Хэн хариуцах: Орхон аймгийн МХГ-ын Худалдаа үйлчилгээний хяналтын улсын байцаагч

Утас: 01352-21231

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 8.00-12.00, 14.00-18.00

Санал, хүсэлт , гомдлыг хаана гаргах: Орхон аймгийн МХГ-ын дарга

Утас: 01352-21050

МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭСНИЙГ ГЭРЧЛЭХ, ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ

Экспортын барааны гарал үүслийг тодорхойлох

1. Монгол Улсаас гарал үүсэлтэй бараанд Монгол улсын бүрэн гарал үүсэлтэй бараа болон Монгол улсад явагдсан үйлдвэрлэлийн явцад үлэмж хэмжээний боловсруулалт орсон барааг тооцно.
2. Дор дурьдсан бараа Монгол улсын бүрэн гарал үүсэлтэй бараанд хамрагдана.
 - а/ Монгол улсын нутаг дэвсгэрээс олборлосон ашигт малтмал
 - б/ Монгол улсын нутаг дэвсгэр дээр ургасан ургамал болон түүнээс гаралтай бүтээгдэхүүн
 - в/ Монгол улсын нутаг дэвсгэр дээр төрж бойжсон амьд мал, амьтан загас, болон эдгээрээс гаралтай бүтээгдэхүүн
 - г/ Монгол улсын хөлөг онгоцоор түүнчлэн түрээслэн авсан хөлөг онгоцоор олборлосон далайн загас агнуурын болон далай бусад бүтээгдэхүүн
 - д/ Монгол улсын нутаг дэвсгэрээс түүхий эд болон ашиглахаар цуглуулсан урьд нь ашиглагдаж байсан эд зүйлс
 - е/ Монгол улсанд явуулсан үйлдвэрлэлийн хаягдал зүйлс
3. Барааг үйлдвэрлэхэд нэгээс дээш орон хамрагдсан тохиолдолд уг бараа Монгол улсын нутаг дэвсгэрт үлэмж хэмжээний боловсруулалтанд орсон нөхцөлд түүнийг Монгол улсын гарал үүсэлтэй бараанд хамааруулна.

Бүрдүүлэх материалууд:

Экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ авахыг хүсэгч иргэн, аж ахуй нэгж, хуулийн этгээд нь н Доорхи маягтын дагуу өргөдөл гаргана. Өргөдөлд дор дурьдсан зүйлийг заасан байвал зохино. Үүнд.

- өргөдөл гаргагчийн нэр, хаяг
- контракт болон нэхэмжлэхний дугаар, он, сар, өдөр
- барааны нэр, код /БТКУС/
- барааны тоо хэмжээ, гэрээнд заасан үнэ
- тээврийн төрөл, маршрут
- экспортлогч орон, боомт

Өргөдөлд дурьдсан мэдээллийн үнэн зөвийг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.

Гарал үүслийн гэрчилгээ олгох өргөдөлд дор дурьдсан **бичиг баримтыг хавсаргасан** байна.

- аж ахуй нэгж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний
- хуулбар, хувь хүний хувьд иргэний үнэмлэхний хуулбар
- гэрээний хуулбар
- нэхэмжлэх
- сав баглаа боодлын хуудас
- давхар захиалгаар гүйцэтгүүлсэн ажлын тухай тодорхойлолт /subcontract/
- гарал үүслийн гэрчилгээний хураамжийн төлбөрийн баримт

Үнэ хураамж: Гарал үүслийн гэрчилгээ олгоход Монгол улсын хууль тогтоомжинд заасны дагуу хураамж ноогдуулна.

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим менежер

Утас : 01352-22643

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр 9.00 -12.00 14.00-17.00 цаг

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНД ЗУРААСАН КОД ОЛГОХ

Нийтлэг үндэслэл:

- 1.1 Монгол Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэрэгдэх «GS1-Mongolia» нийгэмлэгт гишүүнээр элсүүлэх бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох. Түүнтэй холбогдсон асуудлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2 Бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох ажиллагааг Олон Улсын «EAN-International» /Олон Улсын Бараа Бүтээгдэхүүн Дараалалын Байгууллага/ байгууллагаас эрх олгосноор МҮХАҮТ-ын дэрэгдэх «GS1 Mongolia» нийгэмлэг гүйцэтгэнэ.

Бүрдүүлэх материал: Нийгэмлэгт гишүүнээр элсэж бараа бүтээгдэхүүндээ зураасан код авахаар хүсэлт гаргагч иргэн, аж ахуй нэгж хуулийн этгээд хавсаргалтанд заасан маягтын дагуу МҮХАҮТанхимын дэргэдэх «GS1 Mongolia» нийгэмлэгт компанийнхаа талаарх мэдээллийг үнэн зөв, гаргацтай бөглөж өгөх ба мэдээллийн үнэн зөвийг өөрөө хариуцна. Гишүүнээр элсэх өргөдөлд дараах материалыг хавсаргана. Үүнд:

1. Аж ахуй нэгж байгууллагын танилцуулга
2. Улсын бүртгэл гэрчилгээний хуулбар
3. Компаниас зураасан кодны асуудал хариуцсан ажилтан / итгэмжлэгдсэн төлөөлөгч / томилсон тухай албан бичиг
4. МҮХАҮТанхимын дэргэдэх «GS1 Mongolia» нийгэмлэгт гишүүнээр элсүүлэх, бараа бүтээгдэхүүнд зураасан код олгох журам)-тай уншиж танилцсан байх албан бичиг
5. Элсэлтийн хураамж төлсөн баримт

Элсэлтийн хураамж: Элсэлтийн хураамжийн хувь хэмжээ нь «GS1 Mongolia»-аас тухайн компанид олгосон «компанийн дугаар»-ын уртаас хамаарна.

11 оронтой 1-9 хүртэл	150.000 ₮
10 оронтой 1-99 хүртэл	250.000 ₮
9 оронтой 1-999 хүртэл	350.000 ₮

Гишүүний жилийн татвар: Гишүүний жилийн татварын хэмжээ нь ирэх жилд тухайн компанийн зураасан код хэрэглэх бүтээгдэхүүний нэгжийн тооноос хамаарна.

Бүтээгдэхүүний нэгжийн тоо	жилийн татварын хэмжээ
1-9 хүртэл	100.000 ₮
10-19 хүртэл	150.000 ₮
20-29 хүртэл	200.000 ₮
30-39 хүртэл	250.000 ₮ гэх мэт татвартай байна.

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Утас:01352-28001

Ажиллах цаг: ажлын 5 өдөр 9.00 -12.00 14.00 -17.00

ПАТЕНТ, БАРААНЫ ТЭМДГИЙГ БҮРТГҮҮЛЭХЭД ЗУУЧЛАХ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь 1970 онд Монголын анхны оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон. Гишүүн ба гишүүн бус байгууллагууддаа шинэ бүтээл, бараа үйлчилгээний тэмдэг, оюуны өмчийн эрхийг баталгаажуулахад зуучлах үйл ажиллагаа явуулдаг.

Шинэ бүтээлийн мэдүүлэг гаргахад бүрдүүлэх материал:

Шинэ бүтээлийн мэдүүлэг гаргахад дараах материалуудыг тус тус бүрдүүлнэ.

Үүнд :

1. Өргөдлийн маягыг бөглөх.
2. Шинэ бүтээлийн тодорхойлолт
3. Шинэ бүтээлийн томьёлол
4. Холбогдох зураг
5. Хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуйтай холбогдсон шинэ бүтээл нь хүний эрүүл мэнд, биед хохирол учруулахгүйг нотолсон эрүүл ахуйн халдвар судлалын байгууллагын магадлагаа, тодорхойлолт
6. Компаний гэрчилгээний нотриатаар батлуулсан хувь
7. Зохиогчоос өөр этгээд патент эзэмших бол зохиогчоос эрх шилжүүлэн авсан тухай баримт
8. Итгэмжлэх, шилжүүлэх акт
9. Зохиогчийн баталгаа
10. Ажил үйлчилгээний хураамж 16,000 төгрөг Оюуны өмчийн газрын дансанд төлсөн баримт

Бүтээгдэхүүний загвар:

1. Өргөдөл
2. Загварын зураг – 2ширхэг
3. Загварын тодорхойлолт
4. Компаний гэрчилгээний нотриатаар батлуулсан хувь
5. Хэд хэдэн зохиогчтой боловч хэн нэгний нэр дээр патент авах бол бусад зохиогчийн зөвшөөрч баталгаажуулсан баримт
6. Итгэмжлэл
7. Ажил үйлчилгээний хураамж 16,000 төгрөг Оюуны өмчийн газрын дансанд төлсөн баримт

Барааны тэмдэг:

1. Өргөдөл /бүртгүүлэх тухай хүсэлт/
2. Компаний гэрчилгээний нотриатаар батлуулсан хувь
3. Дардас 15 ширхэг /7x5см/
4. Итгэмжлэх
5. Ажил үйлчилгээний хураамж 20000 төгрөг Оюуны өмчийн газрын дансанд төлсөн баримт

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим ажилтан

Утас:01352-22643

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ БА ЦЭЦЭРЛЭГ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг стандарт шаардлагад нийцүүлэх, арга хэмжээг зохицуулахад оршино.

Эрх зүйн орчин: Монгол улсын Боловсролын тухай хуулийн 19.30, 21,22,23,24,25 дугаар зүйл

ЕБС ба цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал:

- Боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг.
- Боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга
- Сургалтын төлөвлөгөө
- Багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг цолны судалгаа
- Сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа
- Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа
- Үүсгэн байгуулагчаас сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ баталгаа
- Байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл

Үйлчилгээний үнэ өртөг:

д/д	Хураамжийн үндэслэл	хураамжийн утга	Үнэ хураамж	Харилцах данс
1.		Тусгай зөвшөөрлийн маягтны үнэ	5000 төгрөг	Голомт банк «Арилдос» ХХК-ны 110202165 тоот данс

Үйлчилгээний үргэжлэх хугацаа: Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаатай уялдуулан тогтооно.

Хэн хариуцах: Орхон аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан ажилтан

Утас: 01352-21514

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр, 8.00-12.00, 14.00-17.00

Санал, хүсэлт, гомдлыг хаана гаргах: Орхон аймгийн ЗДТГазрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Утас: 01352-20454

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Орон нутагт Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон арга хэмжээг зохицуулахад оршино.

Эрх зүйн орчин:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөш олгоход бүрдүүлэх материал:

1. Хүсэлт гаргасан албан тоот
2. ААН-ийн гэрчилгээний хуулбар
3. МХГазраас ажлын байрны дүгнэлт гаргуулна.

Үйлчилгээний үнэ өртөг:

д/д	Хураамжийн үндэслэл	хураамжийн утга	Үнэ хураамж	Харилцах данс
1.	Тэмдэгтийн хураамжийн тухай хууль	Тусгай зөвшөөрлийн үнэ	12500 төгрөг	Төрийн сан 2100000911

Үйлчилгээний үргэжлэх хугацаа:

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг ажлын 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Хэн хариуцах: Орхон аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн Худалдаа үйлчилгээний асуудал хариуцсан ажилтан

Утас: 01352-21168

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр, 8.00-12.00, 14.00-18.00

Санал, хүсэлт, гомдлыг хаана гаргах: Орхон аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Утас: 01352-21910

ТАМХИ ХУДАЛДААЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Орон нутагт тамхи худалдаалах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу явуулах зорилготой.

Эрх зүйн орчин:

- Монгол улсын Тамхины хяналтын тухай хуулийн 7-р зүйлийн 3.
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16-р зүйлийн 3.4 дэх заалт

Тамхи худалдаалах зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал

1. Тамхи худалдаалах тухай хүсэлт
2. МХГазрын ажлын байрны дүгнэлтийн хуулбар
3. Тусгай зөвшөөрлийн үнэ
4. Гэрчилгээний үнэ

Үйлчилгээний үнэ өртөг:

д/д	Хураамжийн үндэслэл	Хураамжийн утга	Үнэ хураамж	Харилцах данс
1.	Тэмдэгтийн хураамжийн тухай хууль	Тусгай зөвшөөрлийн үнэ	12500 төгрөг	Төрийн сан 2100000911

Үйлчилгээний үргэжлэх хугацаа:

Тамхи худалдаалах зөвшөөрлийг ажлын 2 өдөрт багтаан аж ахуйн нэгжид мэдэгдэнэ. Эсвэл НЦҮ-д хүргэнэ.

Хэн хариуцах: Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын ХҮҮЭ ажилтан

Утас. 01352-73811, 99352061

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр, 8.00-12.00, 14.00-17.00

Санал, хүсэлт , гомдлыг хаана гаргах: Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга

Утас:01352- 20965, 99352092

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Үйлчилгээний тодорхойлолт үндэслэл: Эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн яамны болон нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх комиссоос мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлснээр үйлдвэрлэл эрхэлж, эмчлэх, сувилах, оношлох, эм барих, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ эрхлэн явуулах эрхтэй болно.

Эрх зүйн орчин:

- Эрүүл мэндийн хуулийн 12 дугаар зүйлийн 3-р заалт, 19-р зүйл,
- Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 9-р заалт
- Эрүүл мэндийн сайдын 1998 оны А/181, А/269, А/290 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2000 оны 06 тоот тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан журам

Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал

- Өргөдөл буюу үүсгэн байгуулагчдын шийдвэр
- Байгууллагын дүрэм / албан ёсоор батлагдсан/
- Эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүн, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл
- Тоног төхөөрөмжийн жагсаалт
- Эрүүл мэндийн улсын хяналтын албаны дүгнэлт
- Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа
- Хамтын ажиллагааны гэрээ / гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага/
- Төгсөлтийн дараах сургалтын албаны дүгнэлт / эрүүл мэндийн чиглэлээр сургалт явуулах байгууллага/
- Монгол улсын эмийн бүртгэлийн гэрчилгээ, импортлох ба экспортлох эм, урвалж, эмнэлгийн багаж төхөөрөмжийн жагсаалт, тоо хэмжээ

Үйлчилгээний үнэ өртөг:

д/д	Хураамжийн үндэслэл	Хураамжийн утга	Үнэ хураамж	Харилцах данс
1.		Гэрчилгээний үнэ	8000 төгрөг	Төрийн сангийн данс

Үйлчилгээний үргэжлэх хугацаа:

Эрүүл мэндийн байгууллагад тухайн зөвшөөрөл олгох комисс өргөдлийг хүлээн авч ажлын 30 хоногт багтаан ЭМБТЗО комиссын хурлаар оруулж шийдвэр гаргана.

Хэн хариуцах: Орхон аймгийн ЭМГ-ын орлогч дарга

Утас: 01352-21662

Ажиллах цаг: Ажлын 5 өдөр, 8.00-12.00, 14.00-17.00

Санал, хүсэлт, гомдлыг хаана гаргах: Орхон аймгийн ЭМГ-ын дарга

Утас: 01352- 20659

БИЗНЕСИЙГ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ, УРАМШУУЛАХ

Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим /ХАҮТ/ нь 1998 онд байгуулагдсан Төрийн бус байгууллага юм.

Танхим нь орон нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд тус дэмжлэг үзүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудаас гадаад, дотоодын байгууллагатай худалдаа – эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх, өөрийн орны бараа бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх зорилтыг орон нутагт хэрэгжүүлнэ.

Жил бүр (оны эцэст) аж ахуй нэгжийг шилдгийн шилдгээр тодруулдаг. «Entrepreneur» арга хэмжээний зорилго нь аж ахуй нэгж, бизнес эрхлэгчид, хамт олны тухайн оны ажлын амжилтыг хөхүүлэн дэмжиж, урам хайрлан, олон нийтийн хүртээл болгон дэлгэрүүлэхэд оршино.

Шилдэг 10 аж ахуйн нэгжийн номинаци

1. Компаний нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч - Оны шилдэг Энтрепренер
2. Оны шилдэг технологи, know-how нэвтрүүлэгч- Энтрепренер
3. Хүнд үйлдвэрлэлийн салбарын Оны шилдэг байгууллага /уул уурхай, барилга/
4. Хөнгөн үйлдвэрийн Оны шилдэг байгууллага
5. Хүнсний үйлдвэрийн Оны шилдэг байгууллага
6. Худалдааны салбарын Оны шилдэг байгууллага
7. Үйлчилгээний салбарын Оны шилдэг байгууллага
8. Боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн салбарын Оны шилдэг байгууллага
9. Хэвлэл мэдээллийн салбарын Оны шилдэг байгууллага
10. Банк, ББСанхүүгийн Оны шилдэг байгууллага

Оны шилдэг бизнес эрхлэгчид

1. Бичил, жижиг бизнес эрхлэгч
2. Шилдэг маркетер
3. Шилдэг санхүүч
4. Шилдэг бизнес эрхлэгч
5. Шилдэг удирдагч

Бизнес эрхлэгчдийг тодруулах үндсэн шалгуурууд:

- ✓ Компаниас нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
- ✓ Компаний засаглалыг сайжруулах талаар хийсэн ажил, хүрсэн үр дүн. /Үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй тайлагнадаг байдал, хөрөнгө оруулагчид, ажиллагсдын эрх ашгийн хамгаалалт, удирдлагын, хяналтын болон хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгосон байдал /
- ✓ Шинжлэх Ухаан бизнесийн хамтын ажиллагаа, хүрсэн үр дүн.
- ✓ Шинэ үйлдвэр, үйлчилгээний газар дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулж, ажлын байр бий болгосон эсэх.

- ✓ Дотоодын зах зээлд бий болгосон шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- ✓ Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр шинээр бий болгосон экспортын бүтээгдэхүүн
- ✓ Импортын шилдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ нэвтрүүлсэн байдал
- ✓ Байгаль орчныг хамгаалах, цэвэр үйлдвэрлэл хөгжүүлэх талаар хийсэн үйл ажиллагаа, үр дүн
- ✓ Бичил болон жижиг бизнесийг дэмжиж субконтрактаар хамтран хэрэгжүүлсэн ажил, үр дүн
- ✓ Шинээр нэвтрүүлсэн дэвшилтэт техник, технологи, тоног төхөөрөмж

Харгалзах үзүүлэлтүүд:

- Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн байдал. Үүнд: Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, зохиогчийн эрхээ бүртгүүлж патент, гэрчилгээ авсан эсэх
- Зураасан кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдал
- ХАҮТанхимаас зохиосон ажилд оролцсон байдал, гишүүний татвар төлөлт
- Олон улсын болон орон нутгийн чанартай үзэсгэлэн яармагуудад оролцсон байдал
- Боловсрол, мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран ажилласан байдал /Оюутан сурагчдыг дадлагажуулах, сургалтын төлбөрийг хариуцах болон хичээлийн бус цагаар ажлын байраар ханган ажиллуулсан талаар/

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Орхон Аймгийн Засаг Даргын Тамгын Газар

Утас: 01352-22643

БИЗНЕС ӨМГӨӨЛӨЛ

Хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн хүрээнийхний нийтлэг эрх ашиг, санал бодлыг болон тэдний зүгээс гаргаж буй санал санаачлагыг аймгийн засаг захиргааны байгууллагын удирдлагуудад танилцуулах, харилцан зөвлөлдөж зөвлөмж гаргах зорилгоор Орхон аймгийн ХАҮТанхимын дэргэдэх Зөвлөлдөх хороо - Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах чиглэлээр ажиллаж байна.

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Хуулийн зөвлөх

Утас: 01352-28001, 01352- 22643

Ажиллах цаг: ажлын 5 өдөр 9.00 -12.00, 14.00 -17.00

ГАДААД, ДОТООД ХУДАЛДААНЫ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АРБИТР

АРБИТРЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1-р зүйл. Хуулийн зорилт

1.1 Энэхүү хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хоорондын үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай үүссэн харилцааг зохицуулахад оршино.

6-р зүйл. Арбитрын харьяаллын маргаан

6.1 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан арбитрын харьяалалд хамаарна.

11-р зүйл. Арбитрын хэлэлцээрийн ойлголт, хэлбэр

11.1 Арбитрын хэлэлцээр гэж / гэрээний шинж хэлбэр агуулсан эсэхээс үл хамааран/ аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн буюу үүсч болох бүх төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ.

11.2 Арбитрын хэлэлцээрийг бичгийн хэлбэрээр хийх ба талууд уг хэлэлцээрийг маргаан гарахаас өмнө болон гарснаас хойш хэдийд ч хийж болно. Гэхдээ Иргэний хуульд заасан стандарт нөхцөл бүхий гэрээний тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүсэний дараа хийнэ.

Арбитрт нэхэмжлэл гаргах:

Нэхэмжлэлийн өргөдөлд дараах зүйлийг тусгана.

1. талуудын нэр, хаяг
2. маргааны агуулга, үндэслэл, маргаан үүсэх үндэслэл болсон гэрээ
3. нэхэмжилж буй зүйлс, маргааны үнийн дүн
4. арбитрын хэлэлцээр
5. арбитрагчдын тооны талаар өмнө нь ямар нэг тохиролцоо байгаагүй бол хэдэн арбитрагчаар уг маргааныг шийдвэрлүүлэх
6. арбитрын ажиллагааг явуулах газар, хэл, хэрэглэх хууль

Арбитрын загвар заалт:

Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Орхон аймгийн Арбитрт, түүний арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ.

Бид дараах үйлчилгээг үзүүлдэг:

1. хууль эрх зүйн зөвлөгөө өгөх
2. Арбитрын холбогдолтой ном зохиолоор үйлчлэх, мэдээллээр хангах
3. Эрх зүйн, сургалт семинар зохион байгуулах
4. Давагдашгүй хүчин зүйлийн баталгаа гаргах: - газар хөдлөлт, халдварт өвчин, гал түймэр, зуд, үер, дайн дажин зэрэг гай гамшиг

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Арбитрын товчоо

Утас: 01352-28001, 01352-22643

Ажиллах цаг: ажлын 5 өдөр 9.00 -12.00, 14.00 -17.00

Орхон аймаг дахь ХАҮТ-ын Экспорт Импорт Магадлан Шалгах товчоо

Өөрийн орны болон гадаадын байгууллага, хүмүүсийн захиалга, гэрээний үндсэн дээр төрөл бүрийн бараа, тоног төхөөрөмж, түүхий эд экспортлох, импортлох явцад элбэг тохиолддог тоо чанар, иж бүрдэл, гэрээгээр тохиролцсон марк, тип, артикул зөрөх, нийлүүлэлтийн хугацаа хоцрох зэрэг зөрчлүүдийг илрүүлж нийлүүлэгч худалдан авагч хоёрын аль алиных нь эрх ашгийг үл хамгаалах зарчмыг баримтлан хөндлөнгийн экспертизийг хийж баталгаа /серифтикатыг гаргаж өгдөг.

Серифтикатыг нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг эрх зүйн баримт болж хохирлыг барагдуулахаас гадна дотоод гаалийн болон бусад татварын хэмжээг үнэн зөв тогтоож, гэмтэлтэй буюу дутуу ирсэн, чанар муудсан бараа, тоног төхөөрөмж, түүхий эдийн онцгой болон бусад төрлийн татварыг буцаан олгох мөн нийлүүлэгч байгууллага болон даатгалын газартай тооцоо хийхэд үндэслэх баримт нь болдог.

ЭИБМШГазар дараах нэр төрлийн бараанд тоо, чанарын экспертиз хийж байна

- Хүнсний бүх төрлийн бараа
- Өргөн хэрэглээний төрөл бүрийн бараа
- Мебель эдлэл
- Нефть бүтээгдэхүүн
- Автомашин, төрөл бүрийн автомашины сэлбэг
- Барилгын материал
- Эм, Эмнэлгийн бүтээгдэхүүн
- Түүхий эд
- Компьютер, теле-видео техник
- Улаан буудай г.м

Бүрдүүлэх материал:

- 1 Өргөдөл
- 2 Төмөр замын наклад
- 3 Гаалын баримт бичиг
- 4 Тээвэрлэлтийн гэрээ
- 5 Бараа худалдах, худалдан авах гэрээ

Үнийн тариф:

- 1 МҮХАҮТ-ын гишүүн болон байнгын үйлчлүүлэгч байгууллагад 20 хүртэлх хувийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 2 Ажлын бус цагаар буюу амралт, баяр ёслолын үеэр эксперт ажиллуулсан тохиолдолд хөдөлмөрийн хуулинд заасны дагуу тарифыг 2 дахин өсгөж тооцно.
- 3 Эксперт дуудлагыг хүлээн авч ажлын наряд авсан цагаас эхлэн экспертизийн цагийг тооцно.
- 4 Яаралтай үйлчилгээ үзүүлэхэд үндсэн тарифыг 25% нэмэгдүүлэн тооцно.

Хэн хариуцах: Орхон аймаг дахь ХАҮТ-ын дэргэдэх экспертизийн товчоо
Товчооны Эксперт

Утас:01352--28001, 01352-71708

Ажиллах цаг: Ажлын өдрүүдэд 09:00 -12:00 14:00-17:00

ҮЙЛДВЭРЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

2006 оны 10-р сарын 15-ны өдрийн Орхон аймаг дахь ХАҮТанхимын Тэргүүлэгчдийн хурлаар «Үйлдвэрлэл, мэдээллийн төв»-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн. «Үйлдвэрлэл мэдээллийн төв» нь жижиг дунд бизнес эрхлэгчид болон ААНэгж, байгууллагуудад мэдээлэл түгээх, төрөл бүрийн судалгаа хийх, сургалт зохион байгуулах, бизнесийн зөвлөгөө өгөх, гадаад, дотоод түншүүдэд зуучлах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Зах зээлийн эдийн засагт хувь нэмэр болох мэдлэг мэргэжлийг дээшлүүлж чадахуйц, бизнес эрхлэгчдийн удирдлагын болон боловсон хүчний хэрэгцээ шаардлагыг хангасан төв болох

«Үйлдвэрлэл, мэдээллийн төв»-ийн Үндсэн үйл ажиллагаа

1. Мэдээлэл
2. Сургалт
 - Үйлдвэрийн газрын удирдлагуудад зориулсан сургалтын сэдэв
 - Үйлчилгээний газрын удирдлагуудад зориулсан сургалтын сэдэв
 - Залуу эздэд зориулсан зориулсан сургалт
 - Шинээр ААНэгж үүсгэн байгуулагч нарт зориулсан сэдэвт сургалт
3. Судалгаа
4. Зөвлөгөө
5. Төсөл хөтөлбөр бичих, банк санхүүгийн байгууллагад зуучлах

Хамтран ажиллах байгууллагууд:

- Аймгийн ЗДТГазар
- МҮХАҮТанхим
- Германы Техник Хамтын ажиллагааны нийгэмлэг
- Монгол-Японы төв
- Голландын ахмад экспертийн холбоо

Хэн хариуцах: Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Төсөл, маркетингийн менежер

Утас: 01352-28001 01352-22643

ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГИЙН ТОВЧОО

Орхон аймаг дахь ХАҮТ нь гадаад, дотоодын үзэсгэлэн яармаг зохион байгуулж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчилан хэрэглэгчдэд таниулахад оршино. Мөн гадаадын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран эх орондоо болон гадаад орнуудад үзэсгэлэн яармаг зохион байгуулахаас гадна соёл урлаг, бизнесийн цогц арга хэмжээ явуулахыг зорьж байна. ҮЯТовчоо нь төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагуудтай энэхүү салбарт идэвхитэй хамтран ажиллаж, төрөл бүрийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах буюу дэмжлэг тусалцаа, зөвлөгөө өгдөг.

ДОТООДОД

2002 оноос эхлэн Орон нутгийн салбар танхимууд, аймгийн ЗДТГазартай хамтран Түншлэл үзэсгэлэнг тухайн орон нутгийн болон хөрш, зэргэлдээ аймгуудын үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч байгууллага, аж ахуй нэгжүүдийг хамруулан өргөн хүрээтэй зохион байгуулж байна.

ГАДААДАД

МҮХАҮТанхим нь таван жилд нэг удаа зохиогддог Дэлхийн Экспо үзэсгэлэнд Монгол Улсаа төлөөлүүлэн ерөнхий зохион байгуулагчаар оролцох үүрэг хүлээдэг.

Бусад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ үзэсгэлэнг гадаадад жилд хоёроос доошгүй удаа амжилттай зохион байгуулдаг боллоо.

Гадаадын улс орнуудад зохиогдож буй дэлхийд дээгүүр ордог олон улсын болоод салбарын, төрөлжсөн мэргэжлийн чиглэлийн үзэсгэлэнгүүдэд ихэнхидээ экспортын чиглэлээр үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ явуулдаг байгууллагуудыг хамруулахыг голлон анхаарахаас гадна импортын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнд зохион байгуулалттай оролцуулахыг чухалчилдаг.

Хэн хариуцах: Орхон аймаг дахь ХАҮТ

Утас:01352-28001, 01352-71708

Ажиллах цаг: Ажлын өдрүүдэд 09:00 -12:00 14:00-17:00

КОМПАНИУДАД ГАДНЫ ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН УРЬЖ АЖИЛЛУУЛАХ

PUM байгууллага нь 1978 онд байгуулагдсан бөгөөд дадлага туршлагатай ахмад экспертүүдээ байгууллагуудын хүсэлтээр илгээж тухай байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвөлгөө өгөх, сургалтанд хамруулах зэргээр жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг. Экспертүүд нь сайн дурын үндсэн дээр ажилладаг тэтгэвэрт гарсан өндөр мэргэжлийн хүмүүс байдаг. Орхон аймаг дахь ХАҮТ нь PUM буюу Нидерландын ахмад экспертүүдтэй 2005 оноос хойш хамтран ажиллаж байна.

Ахмад экспертийн үйлчилгээг ямар байгууллага авч болох вэ?

Доод тал нь 2 жил үйл ажиллагаа явуулж байгаа, 10-аас доошгүй ажилтантай, үйл ажиллагааны явцад саад бэрхшээл тулгарч ахмад экспертийн зөвөлгөө авах шаардлагатай байгаа аж ахуй нэгжүүд өргөдлийн маягт бөглөж электрон шуудангаар ирүүлнэ.

Эксперт урих хугацаа нь 14 хоногоос 1 сар байх бөгөөд тодорхой хугацааны дараа уг экспертээ дахин урьж үр дүн гартал хамтарч ажиллах боломжтой. Мөн эксперт нь шаардлагатай гэж үзвэл компаний ажилтныг Голландын засгийн газрын зардлаар Голланд улсад дадлага, сургалтанд хамруулах боломжтой.

Эксперт авахад ямар зардал гарах вэ?

Экспертийн Монголд ирэх, буцах онгоцны зардал, даатгал зэргийг Голландын Засгийн газар хариуцдаг бөгөөд хүлээн авагч Монгол тал зөвхөн байр, өдрийн 3 хоол, орчуулагч, ажлын байраар хангах үүрэгтэй. Экспертэд цалин өгөх шаардлагагүй.

Хэн хариуцах:


Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Ажиллах хугацаа:


Ажлын 5 өдөр 9.00 – 12.00 14.00 – 17.00

Бизнес ширээнээс үзүүлэх үйлчилгээний шат дамжлагын зураглал

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙГ БҮРТГЭХ




ЗБН, ББН БҮРТГҮҮЛЭХ




ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР БҮРТГЭХ

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




ХОРШООГ БҮРТГЭХ

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ / ДАНС НЭЭХ , ХААХ/

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ/ ХАЯГ СОЛИХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭМЭХ, ХАСАХ/

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ / УДИРДЛАГА СОЛИХ/

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ /ГИШҮҮН НЭМЭХ, ХАСАХ/

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ /ДҮРМИЙН САН НЭМЭХ, ХАСАХ/

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ /ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭМЭХ /

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАТАН БУУГДСАНЫГ БҮРТГЭХ

БУСАД	ААН	НЦҮ	ТАТВАРЫН ХЭЛТЭС	БАНК	НОТАРИАТ
-------	-----	-----	-----------------	------	----------




БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

БУСАД	БАГ	ААН	НЦҮ	СУМ	БОА
-------	-----	-----	-----	-----	-----



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ, СУНГАХ


БУСАД	БАГ	ААН	НЦҮ	СУМ	ОБХ
-------	-----	-----	-----	-----	-----




ТАЙЛБАР: Галын аюулгүй байдлын дүгнэлт 1жилийн хүчинтэй, сунгалт хийлгэх тохиолдолд тухайн объектад дахин үзлэг хийж,дүгнэлт гаргана.

СТАНДАРТ ОЛГОХ

БУСАД	ИРГЭН, ААН БАЙГУУЛЛАГА	НЦҮ	СХЗТөВ
-------	---------------------------	-----	--------




УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ




ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ

БУСАД	БАГ	ААН	НЦҮ	СУМ	ХАҮТ
-------	-----	-----	-----	-----	------




БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНД ЗУРААСАН КОД ОЛГОХ

БУСАД	БАГ	ААН	НЦҮ	СУМ	ХАҮТ
-------	-----	-----	-----	-----	------




ПАТЕНТ БАРААНЫ ТЭМДЭГ БҮРТГЭХ

БУСАД	БАГ	ААН	НЦҮ	СУМ	ХАҮТ
-------	-----	-----	-----	-----	------




ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ




СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ


БУСАД	БАНК	ААН	НЦҮ	СУМ	АЗДТГ
-------	------	-----	-----	-----	-------



ТАМХИ ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛАГЫН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ



Тайлбар: Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан буюу нарийн мэргэжил олгох, дээшлүүлэх курс хийж, тухайн мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан эмч, эмнэлгийн ажилтанд хувийн эмнэлгийн эрх олгоно.